



ҮНДЭСНИЙ УРЛАГИЙН ИХ ТЕАТРЫН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2025 оны 08 сарын 12 өдөр

Дугаар А/20

Улаанбаатар хот

Байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хорооны зөвлөлийг шинэчлэн батлах тухай

Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.7 дахь заалт, 2023 оны "Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай" хуулийн 13 дугаар зүйл, 2024 оны Монгол Улсын Засгийн газрын "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ" батлах тухай 109 дүгээр тогтоолын хавсралт, 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн Монгол улсын Ёс зүйн хорооны 5 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам"-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Үндэсний Урлагийн их театрын Ёс зүйн дэд хорооны зөвлөлийг 7 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн баталсугай. Үүнд:

Дэд хорооны дарга:

Гишүүд:

Г.Цэрэндулам (хөгжимчин)

Э.Өгөөмөр (хөгжимчин)

Г.Алтанхундага (дуучин)

Б.Бямбадорж (дуучин)

Н.Золзаяа (бүжигчин)

С.Хүрэлбаатар (Тайз жижиг хэрэглэлийн эрхлэгч)

Нарийн бичгийн дарга : Д.Золзаяа (Хөөмийч)

2. Ёс зүйн дэд хорооны ажиллах журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж, нийт уран бүтээлч, ажилтнуудад "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ"-г мөрдүүлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэхийг Ёс зүйн дэд хорооны дарга (Г.Цэрэндулам)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан театрын захирлын 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн А/08 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАХИРАЛ

Г.ЦОГГЭРЭЛ